



Та Сайн дурын даатгалын шимтгэл, Эрүүл мэндийн даатгалын хураамж, Лавлагааны хураамж төлөх гэж байгаа бол Төрийн банкны интернэт, смарт банкны үйлчилгээг ашиглан цахимаар төлөөрэй.

ИНТЕРНЭТЭЭР


1. Та Нийгмийн даатгалын үйлчилгээ цэсээр орж шимтгэл / хураамж/ төлөх аймаг /дүүрэг/, НД-ын байгууллага сонгоорой.




2. Та даатгуулагчийн овог нэр, регистрийн дугаар, төлбөрийн дүн, холбоо барих утас болон хугацааг үнэн зөв оруулаарай.



3. Та гүйлгээний мэдээллээ сайтар шалгасны дараагаар Интернэт банкны гүйлгээний нууц үгээр гүйлгээгээ баталгаажуулна.




4. Таны төлбөрийн баримт и-мэйл хаягт илгээгдэнэ. Та өөрт ойр байрлах салбарт хандан үнэгүй баталгаажуулаарай.





- ✓ Сайн дурын даатгалын шимтгэл
- ✓ Эрүүл мэндийн даатгалын хураамж
- ✓ Лавлагааны хураамж

СМАРТ УТСААР



1. Та Нийгмийн даатгалын үйлчилгээ цэсээр орж шимтгэл /хураамж/ төлөх аймаг /дүүрэг/, НД-ын байгууллага сонгоорой.




2. Та даатгуулагчийн овог нэр, регистрийн дугаар, төлбөрийн дүн, холбоо барих утас болон хугацааг үнэн зөв оруулаарай.

3. Та гүйлгээний мэдээллээ сайтар шалгасны дараагаар Интернэт банкны гүйлгээний нууц үгээр гүйлгээгээ баталгаажуулна.

4. Таны төлбөрийн баримт и-мэйл хаягт илгээгдэнэ. Та өөрт ойр байрлах салбарт хандан үнэгүй баталгаажуулаарай.



ЛАВЛАГААНЫ ХУРААМЖ ТӨЛӨХ

Та Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй эсэх лавлагаа авах бол лавлагааны хураамжийг Төрийн банкны цахим үйлчилгээгээр төлөөрэй.



Мөн даатгуулагч Танд зориулан цахим машинаар доорх нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж байна.

- Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа
- Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас
- Иргэн /даатгуулагч/-нд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай нийгмийн халамж үйлчилгээний газарт гаргах лавлагаа
- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны тухай лавлагаа

Та өөрийн цахим үнэмлэхээрээ үйлчлүүлнэ үү.

Эдгээр машин нь НДЕГ, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст байрлаж байна.

ХАРИЛЦАГЧ ТА ДООРХ ЗААВРЫН ДАГУУ ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨӨРЭЙ.

ИНТЕРНЭТЭЭР

Харилцаны төлбөр | Гар утасны төлбөр/лагс | Бусад төлбөр | **ЗЭЭЛ** | Нийгмийн даатгалын үйлчилгээ

Сайн дурын даатгалын шимтгэл төлөх

Шилжүүлэх дансны дугаар: 101200034247

НД-ын байгууллага: УБ-Баянгол | Сонгох

НД-ын данс: 100000123456 | Автоматаар гарна

Даатгуулагчийн овог нэр: Чинбат Болд

Даатгуулагчийн регистр: Ч | Г | 75042687

Төлбөрийн дүнг: 23 040,00

Даатгуулагчийн утасны дугаар: 99*****



Он: 2014

Эхлэх сар: 11 | Дуусах сар: 11

Гүйлгээний утга: СДД ЧГ75042687 Чинбат Болд

Буцах | **Үргэлжлүүлэх**

SMART УТСААР



Та гүйлгээгээ баталгаажуулахаас өмнө даатгуулагчийн мэдээлэл, мөнгөн дүнг шалгаарай.

Таны гүйлгээний баримт и-мэйл хаягт тань илгээгдэх тул Төрийн банкны дурын салбарт хандан, үнэгүй баталгаажуулж авах боломжтой.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ (ХУРААМЖ)-ИЙГ ЦАХИМААР ТӨЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

ТӨРИЙН БАНКНЫ ИНТЕРНЭТ, СМАРТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР

- Сайн дурын даатгалын шимтгэл
- Эрүүл мэндийн даатгалын хураамж
- Нийгмийн даатгалын лавлагааны хураамж



© 1800-1881

www.statebank.mn

www.facebook.com/StatebankMN

contact@statebank.mn

www.ndaatgal.mn

www.facebook.com/ndaatgal

undeg@ndaatgal.mn

© 1800-1289

© 1900-1199

© 1900-1950



100%
ONLINE

Төрийн банк болон Нийгмийн даатгалын ерөнхий газар хамтран **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ (ХУРААМЖ)-ИЙГ ЦАХИМААР ТӨЛӨХ** үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Харилцагч та нийгмийн даатгалын байгууллага эсвэл банкинд сар бүр очихгүйгээр дараах төлбөрүүдийг цахимаар төлөөрэй. Үүнд:

- ✓ Сайн дурын даатгалын шимтгэл
- ✓ Эрүүл мэндийн даатгалын хураамж
- ✓ Лавлагааны хураамж

Бид Таны төлбөрийн мэдээллийг Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэлийн системд цаг алдалгүй онлайнгаар илгээх тул та үнэт цагаа хэмнээрэй.

ТӨРИЙН БАНКНЫ ИНТЕРНЭТ, СМАРТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Та Төрийн банкны Интернэт, смарт банкны үйлчилгээг ашиглан дараах үйлчилгээг авах боломжтой. Үүнд:

- Бүх төрлийн шилжүүлэг хийх;
- Хэрэглээний төлбөр болон гар утасны төлбөр төлөх, нэгжийн карт худалдан авах;
- Нийгмийн даатгалын үйлчилгээний төлбөр төлөх
- АТМ-аас картгүйгээр бэлэн мөнгө авах Цахим төгрөг үйлчилгээ;
- Хадгаламж барьцаалсан зээл авах, зээлийн төлбөр төлөх;
- Данс нээх;
- Мобайл, мессеж банкны үйлчилгээнд бүртгүүлэх;
- Карт захиалах;
- Захиалгат шилжүүлэг бүртгэх;

Мөн гар утсанд Төрийн банкны аппликейшныг татаж дээрх үйлчилгээг аваарай.

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ



Сайн дурын даатгалд дараах иргэд даатгуулна:

- Малчин
- Газар тариалан эрхлэгч /ногоочин/
- Бичил уурхай эрхлэгч
- Жолооч /такси, зорчигч болон ачаа, хот хоорондын тээврийн жолооч/
- Оюутан /бакалавр, магистр, докторант, бусад/
- Ажилгүй иргэн
- Хувиараа бизнес эрхлэгч
- Ажлаасаа захиргааны цалингүй чөлөө түр хугацаанд авсан иргэн
- Гадаадын төслийн нэгжид ажилладаг иргэн
- Гадаад улс оронд оршин суугч иргэн
- Бусад

Даатгуулагч өөрийн мэдүүлсэн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дараах хувь хэмжээгээр шимтгэл төлнө.

Тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээ

10%

Тэтгэмжийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээ

1%

ҮОМШӨ-ийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээ

1%

Шимтгэл тооцох орлогын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй (2013.09.01-нээс 192 000 төгрөг), дээд хэмжээ нь доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

Нийгмийн даатгалд даатгуулах гэрээ байгуулахдаа:

- Иргэн сайн дураар даатгуулах хүсэлт гаргана.
- Нийгмийн даатгалын дэвтэр /байхгүй бол шинээр дэвтэр нээлгэнэ/.
- Цээж зураг 1 хувь /4x3 хэмжээтэй/.
- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын орлогоо тодорхойлно.
- Шимтгэл төлөх хугацаагаа /сар, улирал, хагас жилээр/ тохирно.
- Гэрээ байгуулахдаа нэг сараас доошгүй хугацаанд ногдох шимтгэл төлнө.

Гэрээ сунгах хүсэлтээ гэрээ дуусахаас өмнө нийгмийн даатгалын хэлтэст гаргасан тохиолдолд гэрээний хугацааг сунгана.

Гүйлгээний утганд даатгуулагчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, хэдэн оны аль сар /улирал, хагас жил/-ын шимтгэл төлж байгааг тодорхой бичнэ.

Та Төрийн банкны интернэт, смарт банкаар сайн дурын даатгалын шимтгэлээ төлөөд харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байцаагч дээр очиж бичилтээ хийлгээрэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ ТӨЛӨХ



Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар даатгуулагч эрүүл мэндийн эрсдэлд орох үед даатгалын сангаас санхүүгийн дэмжлэг, тусламж бүхий эрүүл мэндийн үйлчилгээний зардлын төлбөрийг авах боломжтой.

Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол:

Та эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөнөөр тухайн жилдээ 8 төрлийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх эрхээр хангагдана. Үүнд:

- Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
- Амбулаторийн тусламж, үйлчилгээ;
- Оношлогоо шинжилгээ;
- Уламжлалт эмчилгээ;
- Нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ/ рашаан, сувиллын зардал/;
- Өдрийн эмчилгээ;
- Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт.

Даатгуулагч нь жилд **8040** төгрөгийн хураамжийг төлснөөр эрүүл мэндийн даатгалын сангаас **1 800 000** төгрөг хүртэлх тусламж, үйлчилгээний зардлыг төлүүлэх боломжтой юм.